



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар A/333

Чойбалсан

Г Түгээмэл тархацтай ашигт малтмалын 7
ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 11.2.6 19 дүгээр зүйлийн 19.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.2.2, 16.2.4 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дорнод аймгийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 193 дугаартай магадлалыг үндэслэн Матад сум, 6 дугаар баг, Матадын Чулуу гэх газарт 181,6 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Хард Стоун" ХХК-д олгосугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Дамдинбазар)-т үүрэг болгосугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайд явуулж буй үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Матад сумын засаг дарга (Э.Саранхүү), Салбарын хяналт, зохицуулалтын хэлтэс (Г.Эрдэнэбаатар), Байгаль орчны газар (А.Гантулга), ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг аймгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (В.Цэнгэлмаа)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Гэрэлцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ЁЛ



My computer D/ Zakhiramj
2125010968